



Монгол Улсын  
Төрийн мэдээлэл  
№ 05 дугаар сарын 5  
№17 /638/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
Сенхийлэгчийн  
зорлиг

594

Монгол Улсын  
Асгийн газрын  
тогтоол

596

Монгол Улсын  
Асгийн газрын  
тогтоол

596

**Нийтийн биеийн тамир,  
спортыг хөгжүүлэх тухай**

**Зорчигч тээврийн нислэг зохион  
байгуулах тухай**

**Хөтөлбөр батлах тухай**

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

124. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 15 593

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

125. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлдэг тухай Дугаар 53 594

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

126. Ургамлын үр, үрслэг, суулган нэвтрүүлдэг, үржлийн мал, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортолох боомтын тухай Дугаар 22 594

127. Зорчигч тээврийн нислэг зохион байгуулах тухай Дугаар 30 596

128. Хөтөлбөр батлах тухай Дугаар 31 596

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

129. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 02 615

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар  
хот

**Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газраас 2009 оны 5 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 3 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

### Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай

Хүүхэд, залуучуудыг нийтийн биеийн тамираар хичээллүүлэх, эрүүл чийрэг бие бялдар, өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, олимп, тив, дэлхийн спортын уралдаан, тэмцээнд амжилттай оролцох баг, тамирчдыг бэлтгэх үндсийг бий болгох зорилгоор "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь.

1. Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар жил бүрийн дөрөвдүгээр сард явуулж, үнэлэлт, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.

2. Биеийн тамир, спортыг нийтийн үйл хэрэг болгох зорилгоор дунд болон их, дээд сургуулиудад биеийн тамир, спортыг сургалтын тэргүүлэх чиглэл болгож, сурагч, оюутнуудыг спортоор хичээллэх таатай орчин нөхцлөөр хангах, спортын хамтлаг, клубын тогтолцоог нэвтрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, тамирчид, багш дасгалжуулагчид, бизнесийн бүх байгууллага, нийт ард иргэдэд уриалсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 01 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар  
хот

### Ургамлын үр, үрслэг, суулгац нэвтрүүлэх, үржлийн мал, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортлох боомтын тухай

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай



хуулийн 5.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын хилийн дараахь боомтуудаар ургамлын үр, үрслэг, суулгац нэвтрүүлсүгэй:

- 1) Өмнөговь аймгийн Шивээхүрэн;
- 2) Өмнөговь аймгийн Гашуунсухайт

2. Улсын хилийн дараахь боомтуудаар үржлийн мал экспортлохыг зөвшөөрсүгэй:

- 1) Өмнөговь аймгийн Шивээхүрэн;
- 2) Өмнөговь аймгийн Гашуунсухайт;
- 3) Булган аймгийн Бага-Илэнх;
- 4) Сүхбаатар аймгийн Бичигт;
- 5) Ховд аймгийн Булган;
- 6) Говь-Алтай аймгийн Бургастай;
- 7) Баян-Өлгий аймгийн Цагааннуур;
- 8) Завхан аймгийн Арцсуурь;
- 9) Дорнод аймгийн Хаеирга;
- 10) Дорнод аймгийн Эрээнцав;
- 11) Увс аймгийн Боршоо.

3. Улсын хилийн дараахь боомтуудаар түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортлохыг зөвшөөрсүгэй:

- 1) Өмнөговь аймгийн Шивээхүрэн;
- 2) Өмнөговь аймгийн Гашуунсухайт;
- 3) Булган аймгийн Бага-Илэнх;
- 4) Сүхбаатар аймгийн Бичигт;
- 5) Говь-Алтай аймгийн Бургастай.

4. Энэ тогтоолын 1, 2, 3 дугаар зүйлийг 2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй.

5. "Жагсаалт, журам батлах тухай" Засгийн газрын 2003 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 173 дугаар тогтоолоор баталсан "Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөөрөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт"-ын Нэг, Хоёр, Дөрөв дэх хэсгийн "Ховд аймгийн Ярант" гэснийг "Ховд аймгийн Булган" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**Т.БАДАМЖУНАЙ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 2 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар  
хот

### Зорчигч тээврийн нислэг зохион байгуулах тухай

Өвөлжилтийн байдал хүндэрч, зорчигч тээврийн үйлчилгээг авто тээврээр хүргэх боломж хязгаарлагдсан Ховд, Баян-Өлгий аймгийн алслагдсан зарим сумын иргэдэд түр хугацаагаар агаарын тээврийн үйлчилгээ хүргэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Булган сумын чиглэлд 2010 оны 2 дугаар сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний хооронд хуваарьт нислэг гүйцэтгэхэд шаардагдах 81.200.000 (наян нэгэн сая хоёр зуун мянган) хүртэл төгрөгийн нөхөн олговрыг Засгийн газрын нөөц сангаас гаргаж гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

2. Агаарын хөлөг хүлээн авах Ховд аймгийн Булган сумын нисэх буудлын аюулгүй ажиллагааг хангаж, хуваарьт нислэгийг зохион байгуулан нислэгийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД

Х.БАТТУЛГА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 2 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар  
хот

### Хөтөлбөр батлах тухай

Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Боловсрол" үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.



2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг жил бүрийн улсын төсөв, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгаж, хандивлагч байгууллагын хөтөлбөр, төсөлд хамруулан ажиллахыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

4. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хөтөлбөрийн хэрэгжилтийн 1 дүгээр үе шатны тайланг 2015 онд, 2 дугаар үе шатны тайлан болон хүрсэн үр дүнгийн талаар 2021 оны 8 дугаар сард багтаан тус тус Засгийн газарт танилцуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Е.ОТГОНБАЯР**

Засгийн газрын 2010 оны 31 дүгээр  
тогтоолын хавсралт

### **"БОЛОВСРОЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2010-2021 ОН)**

#### **Нэг. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт: "Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ. "Боловсрол" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ" гэж заасан.

1995 онд Улсын Их Хурлаар баталсан Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого нь боловсролд хийсэн өөрчлөлт шинэчлэлтийн үйл ажиллагааны үзэл баримтлал болж ирсэн бөгөөд түүнд тулгуурлан Монгол Улсын Засгийн газраас боловсролын салбарт 1997-2005 онд хийх өөрчлөлтийн үндсэн чиглэл (1997), Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-1, Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр (1995), Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2001),

Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөрийн 1, 2, 3 дугаар үе шат, Сургуулийн өмнөх боловсролын 1, 2 дугаар шат (1995, 2001), Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (1997), Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (1998) зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдан хэрэгжсэн байна. Түүнчлэн Боловсролын багц хууль (1995, 1998, 2002, 2006, 2008), Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008), Монгол Улсын Боловсролыг 2006-2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө (2006), Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр (2004), Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-2(2008), Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр (2008), Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр (2008), Монгол Улсын Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр (2008), Дэвшилтэт технологийг хөгжүүлэх дэд хөтөлбөр, Төрийн өмчийн их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалтын ажлыг дэмжих дэд хөтөлбөр, Залуу судлаачдыг бэлтгэх, дэмжих дэд хөтөлбөр, Шинжлэх ухаан, техникийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө (2008) зэрэг бодлогын баримт бичиг тус тус батлагдан хэрэгжиж байна.

Гэсэн хэдий ч дээр дурдсан хөтөлбөр, төлөвлөгөөнүүд нь боловсролын салбарын өмнө тулгамдсан асуудлыг иж бүрнээр нь цогц шинжтэй хамарч чадаагүй байна. Иймээс эдгээр хөтөлбөрүүдийг өөртөө дэд хөтөлбөр шинжтэйгээр багтаасан иж бүрэн, цогц хөтөлбөр батлан гаргах шаардлагатай болсон юм.

### **Хоёр. Монгол Улсын боловсролын салбарын 2021 он хүртэл хэрэгжүүлэх үндсэн зорилт**

Бүх шатны боловсролын тогтолцооны нийгмийн шинэ шаардлагад нийцсэн тасралтгүй хөгжлийг хангаж, боловсролын үйлчилгээний хүртээмжид баримжаалсан бодлогоос боловсролын чанар, үр өгөөжийг тогтмол дээшлүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлэхэд чиглэсэн бодлогод шилжих нь боловсролын шинэчлэлийн онцлог байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дараахь үндсэн зорилтыг хэрэгжүүлнэ.

-сургуулийн өмнөх болон бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлэх,

-дээд боловсролын шинэчлэлийг эрчимжүүлж, олон улсад өрсөлдөх чадвартай, олон улсын жишигт нийцсэн тогтолцоог бий болгох,



-мэргэжлийн боловсрол, сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээл, мэдлэг бүтээх эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх;

-албан бус боловсролыг шинэчлэн өргөтгөж, иргэдэд чиглэсэн бүх нийтийн насан туршийн боловсролын нээлттэй тогтолцоог төлөвшүүлэх;

### **Гурав. Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

-хөтөлбөрийн зорилго бодитой, зорилтууд хэрэгжихүйц байх;

-хөтөлбөрийн хэрэгжилт нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлага, иргэд, суралцагчид, олон нийтийн санаачилга, оролцоонд тулгуурласан байх;

-Монгол Улсын боловсролын агуулга, түүний түвшин, сургалтын арга зүй, үнэлгээний шинэчлэл нь өндөр хөгжилтэй орнуудын жишигт баримжаалсан байх;

-иргэд, суралцагчдын эзэмших боловсролын агуулга, арга хэлбэр нь сонгох боломж олгосон, уян хатан, нээлттэй байх;

-боловсролын шинэчлэл, өөрчлөлт нь бүх нийтийн насан туршийн боловсролын хэрэгцээ шаардлагад нийцсэн байх.

### **Дөрөв. Хөтөлбөрийн стратегийн зорилтууд**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь стратегийг удирдлага болгоно:

Стратегийн зорилт 1. Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх;

Стратегийн зорилт 2. Бүх түвшний боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг суралцагчийн хэрэгцээ, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох;

Стратегийн зорилт 3. Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин, урамшуулал, нийгмийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, хөрөнгө оруулалтын хэмжээ, үр өгөөжийг нэмэгдүүлэх;

Стратегийн зорилт 4. Боловсролын тогтолцоог боловсронгуй





болгон олон улсын жишигт ойртуулахад төрийн гүйцэтгэх үүрэг, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх;

Стратегийн зорилт 5. Иргэд боловсролоо сайжруулж, ажил мэргэжлээрээ хөрвөн суралцаж байх бодит боломж олгосон боловсролын нээлттэй агуулга, уян хатан арга хэлбэрийг бий болгох;

Стратегийн зорилт 6. Сургууль төвтэй менежментийг хөгжүүлж, сургалтын байгууллагын бүтэц, хэв шинж, байршлын зураглалыг шинэчлэн мөрдөх.

### **Тав. Стратегийн зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

Стратегийн зорилт 1-ийн хүрээнд:

1. Хөдөөгийн малчин өрхийн 0-5 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг нүүдлийн аж байдалд нь тохируулан зохион байгуулж, бага насны хүүхэд сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх:

-бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах сургалтын хамрах хүрээг өргөжүүлэх;

-цэцэрлэгийн барилга барих, өргөтгөх, багийг гэр цэцэрлэгээр хангах ажлыг эрчимжүүлэх;

-төрийн бус өмчийн хэлбэрийн цэцэрлэгийг бодлогоор дэмжих;

-хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийн сургалтын агуулга, арга зүйн стандарт боловсруулж мөрдөх.

2. Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчид болон багш, ажиллагчдын хүйсийн тэгш байдлыг хангах:

-сургууль завсардалт, анги улирах бодит шалтгааныг тодруулан судалгаа хийж, цаашид тогтвортой бууруулах арга замыг тодорхойлох;

-хөвгүүдийн боловсролыг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

-сурган хүмүүжүүлэх салбар дахь хүйсийн тэгш байдлыг бодлогоор дэмжих;

-боловсролын салбарын хөгжлийн асуудлаар шийдвэр гаргах



түвшин дэх хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

### 3. Боловсрол нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх:

-сургуулийн гадна байгаа сургуулийн насны хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

-боловсролын стандарттай уялдуулан бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох;

-сургууль завсардсан хүүхэд, залуучуудад бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр боловсрол нөхөн олгох тогтолцоо бүрдүүлэх.

### 4. Бага, дунд боловсролын үйлчилгээнд хот, хөдөөгийн ялгааг багасгах:

-сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгын чанар, хүчин чадлыг нэмэгдүүлж, хүүхэд суралцах, төлөвших ээлтэй орчин, тэгш боломжийг бүрдүүлэх;

-хотын сургуулийн ачааллыг бууруулах, хот болон хөдөөгийн сургуулийн тавилга, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлж, тэдгээрийн хүртээмж, ашиглалтыг сайжруулах цогц арга хэмжээ авах;

-ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тохилог орчин бүрдүүлж, дотуур байранд суух хүүхдийн тоог 2.1 дахин нэмэгдүүлэх;

-ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын "Үдийн цай" хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн физиологийн хэрэгцээнд нийцсэн шимт бодисоор баялаг, илчлэг чанар сайтай "Үдийн хоол"-ны хөтөлбөр болгон өргөжүүлэх.

### 5. Зургаан настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах:

-зургаан настай хүүхдийн сургуульд бэлтгэх стандартыг мөрдөж түүний хэрэгжилтийг хангахад эцэг эх, олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх;

-зургаан настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйг боловсронгуй болгох.



6. Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшинг 2010 он гэхэд 99.0 хувьд хүргэх:

-хүн амын бичиг үсгийн боловсролын түвшин тогтоох олон улсын аргачлалаар насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын түвшин тогтоох судалгаа явуулах;

-бичиг үсэг үл мэдэгчдийн хувь хэмжээг бууруулах, насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсрол дээшлүүлэх тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.

Стратегийн зорилт 2-ын хүрээнд:

1. Шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан боловсролын стандартын шалгуурыг нарийвчлан тогтоох:

-бүх шатны боловсролын агуулгын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөрт хуульд заасан хугацаанд үнэлгээ хийж, тэдгээрийг дэлхийн өндөр хөгжилтэй орны жишигт ойртуулан боловсронгуй болгох;

-боловсролын үйлчилгээний орчны стандартыг боловсруулж мөрдөх;

-ахлах сургуульд суралцагчдын суралцах идэвх, сонирхлыг дэмжсэн, ажил, мэргэжлийн сонголтыг хүндэтгэсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж мөрдөх;

-үндэсний хэмжээнд бага, дунд сургуулийн сурах бичгийн чанарын судалгаа хийж, суралцагчдыг стандартын шаардлага хангасан сурах бичгээр хангах;

-бага, дунд боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгож шинэчлэх;

-суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тогтолцоог шинэчилж, олон улсын үнэлгээний сүлжээнд хамрагдах;

-бүх нийтийн иргэний боловсрол болон эрүүл мэнд, байгаль орчин, улс төр, мэдээллийн технологийн боловсролд чиглэсэн албан бус сургалтуудыг эрчимжүүлэх.

2. Бүх түвшний боловсролын агуулгад тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгах, үндэсний түүх, соёлыг бахархан дээдэлж, бусдын соёлд хүндэтгэлтэй хандах үзэл, бүтээлчээр сэтгэх мэдлэг, чадвар төлөвшүүлэх.

-суралцагчид бүтээлчээр сэтгэх мэдлэг, чадвар эзэмших, бие даан болон хамтдаа нийгэмшин төлөвших чиглэлээр хийсэн боловсролын агуулга, арга зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх;

-хүмүүнлэгийн ухааны боловсролын агуулгыг суралцагчдад үндэсний ухамсар, мэдрэмж төлөвшүүлэхэд чиглүүлэн боловсронгуй болгох;

-залуучуудад эх орон, ард түмнийхээ түүх, соёлоор бахархах үзэл, үндэсний соёлыг дээдлэх, бусдын соёлд хүндэтгэлтэй хандах хандлага төлөвшүүлэх;

-суралцагчдад шинжлэх ухааны мэдлэг, хөдөлмөрийн дадал чадвар, иргэний боловсролыг төлөвшүүлэхэд чиглэсэн шинэ чиг хандлагыг боловсролын агуулгад тухай бүр тусган хэрэгжүүлэх.

3. Бүх шатны сургуулийг олон улсын боловсролын нийтлэг жишигт нийцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр хичээллэх боломжоор хангах.

-олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Кембриджийн боловсролын стандарт, хөтөлбөрөөр хичээллэдэг төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудыг байгуулах;

-олон улсын бакалавриат /IB/-ын диплом олгох ерөнхий боловсролын сургууль байгуулахыг дэмжих;

-мэргэжлийн боловсрол, сургалтад чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг бүрэн нэвтрүүлэх;

-мэргэжлийн болон техникийн боловсролын сургуулиудын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг эрчимжүүлэх;

-мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын агуулгын залгамж холбоо болон судалгаа, сургалт, үйлдвэрлэлийн нэгдлийг гүнзгийрүүлэх.

4. Боловсролын өөрчлөлт шинэчлэлийг туршин зүгшрүүлэх лаборатори сургуулийн бүтцийг бий болгох.

-ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн сурагчийн авъяас билгийг тодруулан, хөгжил төлөвшлийг дэмжиж, хүүхдийн цаашид суралцах чиг баримжааг тодруулахад ашиглах;



-ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх туршилтын менежментийг боловсронгуй болгоно.

5. Бүх нийтийн монгол хэл, бичгийн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, бүх шатны сургуульд эх хэлээ төгс эзэмшиж ашиглах, бичих, илтгэх ур чадварыг хөгжүүлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх:

-монгол хэл, бичгийн хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

-албан болон албан бус сургалтаар иргэдэд монгол бичиг сургах, монгол бичгийн судалгаа, сурталчилгааг өргөжүүлэх зорилгоор хүн амын монгол хэл, бичгийн боловсрол, бичих, илтгэх ур чадварыг дээшлүүлэх үндэсний дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

6. Бүх нийтийн англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, 2015 он хүртэлх хугацаанд дээд боловсрол эзэмшигчдийг ажил, мэргэжлийн шаардлагатай мэдээллийг англи хэлээр ашиглах чадвартай болгох:

-Англи хэлний үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, бүх нийтийн англи хэлний боловсролын өнөөгийн байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах;

-Англи хэлний боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэх, сургалтын таатай орчин бүрдүүлэх, багшлах боловсон хүчин, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөрт өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх.

7. Боловсролын хөгжлийн бодлого, шинэчлэлийн онол-арга зүйн судалгааны чадавхийг нэмэгдүүлж, боловсролын шинэчлэлийн санаачилгыг дэмжих.

-боловсролын хөгжлийн бодлогод дүн шинжилгээ хийх, шинэчлэлийн онол-арга зүйн үндсийг боловсруулах судалгааны чадавхийг бэхжүүлэхэд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

-боловсрол судлалын суурь болон хавсарга судалгаа хийх чадавхийг нэмэгдүүлэх;

-боловсролын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд нийгэм, олон нийт, хувийн хэвшлийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар боловсролыг бүх нийтийн үйлс болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлэх;

-боловсролын талаар үндэсний болон орон нутгийн түвшинд үйл



ажиллагаа явуулдаг байгууллага, нийгмийн институцийн үүрэг, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох.

Стратегийн зорилт 3-ын хүрээнд:

1. Багш, удирдах ажилтан бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог хөгжүүлж, энэ чиглэлд мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх:

-Багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;

-бага, дунд боловсролын багш мэргэжлээр амжилттай суралцагчдад тэтгэлэг олгох;

-Багш боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн мөрдөж, уг мэргэжлээр суралцагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

-багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарын чадавхийг дээшлүүлэх;

-бүх түвшний сургуулийн удирдах ажилтан бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

-бүх шатны сургуулийг чадварлаг, мэргэжлийн өндөр ёс зүйтэй багшаар хангах арга механизмыг боловсронгуй болгох;

-багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын технологи болон материаллаг баазыг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх;

-боловсролын салбарын хөрөнгө оруулалтын нийт зардлын 15-аас доошгүй хувийг багш нарын мэргэжил дээшлүүлэхэд зарцуулах, сургуулийн төсөвт багш нарын мэргэшил дээшлүүлэх бие даасан зардлын ангиллыг бий болгох;

-мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш бэлтгэх тогтолцоог шинэчлэх;

-сургууль төвтэй мэргэшил дээшлүүлэх тогтолцоог төлөвшүүлэхэд шаардагдах санхүүжилтийн арга механизмыг боловсронгуй болгох;

-боловсролын хөгжлийн талаархи судалгаа, шинжилгээний ажлыг



өргөжүүлэх;

-их, дээд сургуулийн багшийг чадавхижуулах тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

-дээд боловсролын сургалтын байгууллагад гадаадын өндөр хөгжилтэй орнуудаас нарийн мэргэжлийн судлаач багш урьж ажиллуулахыг дэмжих;

-их, дээд сургуулийн судлаач багшийг гадаадад бэлтгэх, урт болон богино хугацааны сургалтад хамруулах;

-мэргэшил дээшлүүлэх, мэргэжлийн хөгжлийн бусад үйл ажиллагаанд мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцох боломжийг нэмэгдүүлэх.

2. Багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны ажлын чанар, хөдөлмөрийн үр бүтээлийг үнэлэх шалгууруудыг зөв тогтоож, цалин хөлс нэмэгдүүлэх, урамшуулал олгох зэргээр нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулах.

-багш, сургуулийн удирдах ажилтны ажлын ачааллыг оновчтой тогтоож, тэдний ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн явц, үр дүнгийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, арга хэлбэрийг боловсронгуй болгох;

-дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр багшаар орж байгаа хүмүүст сургах зүйн боловсрол олгож, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох.

3. Орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль цаг уурын онцлогийг харгалзан багшлах боловсон хүчний тогтвортой ажиллах, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх.

-бүх шатны сургуулийн багш нарт газар нутгийн алслал, цаг уурын онцлог, амьжиргааны өртөгтэй холбогдуулан онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох асуудлыг судалж шийдвэрлэх;

-орон нутгийг мэргэжлийн багшаар хангах, тэднийг тогтвортой ажиллуулах эдийн засаг, эрх зүйн орчныг сайжруулах;

-орон сууцны хөтөлбөрт бүх шатны сургуулийн багш нарыг хамруулах бодлого баримтлах.

Стратегийн зорилт 4-ийн хүрээнд:



1. Их, дээд сургуулийг хотхон байдлаар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх:

-төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчныг тасралтгүй сайжруулах, төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

-судалгааны их сургууль бий болгох суурь нөхцөлийг бүрдүүлж, өндөр хөгжилтэй орны их сургуулийн жишигт нийцэх судалгааны их сургуулийн хотхон байгуулах бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эхлүүлэх институцийг бий болгох.

2. Сургалтын дэвшилтэт арга барил бүхий гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн сургалтын төвүүдийг байгуулах, дунд сургууль төгсөгчдөд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхийг бүх талаар дэмжих:

-боловсролын салбарт гадаадын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчныг бий болгох;

-Мянганы сорилын сангийн шугамаар мэргэжлийн боловсрол болон сургалтын байгууллага, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх;

-ахлах сургуулийн суралцагчдад мэргэжил эзэмшүүлэх сургууль дундын төвүүдийг байгуулах.

3. Боловсролын чанарыг дээшлүүлэхэд төрийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх:

-дээд боловсролын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, дээд боловсролын салбарын хүрээнд нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудыг боловсронгуй болгох;

-төрийн бус өмчийн сургуулиудын бүтцийг оновчтой болгоход чиглэсэн урамшуулал, дэмжлэгийн механизм бүрдүүлэх;

-дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны чиглэл тус бүрт тавих хэм хэмжээг далхийн тэргүүлэх сургуулиудын түвшинг баримжаалан шинэчлэн тогтоох;

-магадлан итгэмжлэлийн тогтолцоог шинэ шатанд гаргах;

-дээд боловсролын стандартыг боловсронгуй болгох замаар





чанарын дэвшил гаргах нөхцөлийг бүрдүүлэх;

-дээд боловсролын чанарын удирдлагын тогтолцооны олон улсын туршлагыг дээд боловсролын салбарт нэвтрүүлэх санаачилгыг дэмжиж, чанарын үнэлгээний шинэ тогтолцоог бүрдүүлэх;

-бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартын хэрэгжилтийг хөндлөнгөөс үнэлэх тогтолцоог бий болгох;

-бага, дунд, ахлах ангийн сурагчдын сурлагын амжилтыг улсын хэмжээнд хоёр жил тутам үнэлдэг болох;

-ерөнхий шалгалтыг хоёр шаттай болгож, эхний шатны заавал өгөх шалгалт, босго оноог тогтоож мөрдүүлэх;

-бүх шатны сургалтын байгууллагыг 5 жил тутамд төрөөс аттестатчилах;

-албан бус боловсролын сургалтын орчинг сайжруулах;

-иргэдэд чиглэсэн бүх нийтийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах.

Стратегийн зорилт 5-ын хүрээнд:

1. Үндэсний тэргүүлэх мэргэжлийн чиглэлийг бодлогоор дэмжих эрх зүйн орчин бүрдүүлэх, авьяас билэгтэй оюутан, сурагчийг дэмжих арга механизмыг оновчтой болгох;

-өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантурт суралцагчдын тоог нэмэгдүүлж, суралцах мэргэжлийн чиглэлийг үндэсний эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан их, дээд сургуулийн багш нарыг түлхүү хамруулах, тэдний эх орондоо эргэн ирж ажиллах боломж, нөхцөлийг сайжруулах;

-уул уурхай, газрын тос, эрчим хүч, биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологийн чиглэлээр залуу судлаачдыг бэлтгэх, дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлэх;

-билэг авьяастай суралцагчийг бакалавр, магистрантур, докторантурт суралцахад дэмжих зээл, тусламж, тэтгэлгийн тогтолцоог боловсронгуй болгож, магистрант, докторантад сурлагын болон эрдэм шинжилгээ-зохиож бүтээх ажлын амжилтаас нь хамааруулан тэтгэлэг олгодог болох;



-гадаад оронд боловсрол эзэмшсэн залуучуудыг эх орондоо эргэн ирэх бодлого, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх.

2. Техникийн боловсрол, мэргэжлийн сургалт, дээд боловсролын төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулах:

-боловсролын салбарын бодлого төлөвлөлтийг шинэ шатанд гаргаж, удирдлагын чадавхи, ур чадвар, манлайллыг сайжруулах;

-бэлтгэн гаргаж буй дээд боловсролтой мэргэжилтний тоо, чанарыг хөдөлмөрийн болон мэдлэг бүтээх эрэлтэд нийцүүлж, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

3. Их сургуулийн бие даасан байдлыг баталгаажуулан, их сургуулийн шинжлэх ухааны чадавхийг дээшлүүлэхэд төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх:

-их сургуулийн эрдэм шинжилгээний ажлыг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

-их сургуулийн эрх зүйн байдлын талаар хуулийн төсөл боловсруулах;

-Шинжлэх ухааны академитай хамтран шинжлэх ухааны салбар бүрээр эрдэм шинжилгээний өгүүлэгийг мэргэжлийн үнэлгээнд үндэслэн шилж сонгож хэвлэдэг мэргэжлийн сэтгүүлийг улсын хэмжээнд нэгтгэн гаргах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

4. Иргэдэд чиглэсэн насан туршийн боловсролын тогтолцоог бий болгох:

-иргэдийн хэрэгцээнд тулгуурласан онлайн сургалтыг хөгжүүлэх;

-ажилгүй хүмүүс, гэрийн эзэгтэй, өндөр настанд зориулсан мэргэжил олгох, дахин мэргэшүүлэх, хөгжүүлэх сургалт явуулах;

-бүх шатны боловсролын нээлттэй болон зайны сургалтын төв байгуулж ажиллуулах;

-нээлттэй их сургууль байгуулах;

-төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага нь эрхлэх ажил, үйлчилгээнийхээ хүрээнд иргэдэд бүх нийтийн боловсрол эзэмшүүлэх үйлсад оруулах хувь нэмэр, нийгмийн хариуцлагыг

нь нэмэгдүүлэх.

Стратегийн зорилт 6-гийн хүрээнд:

1. Боловсролын салбарын захиргааны болон мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох:

-сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтныг салбарын мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор томилж, чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох,

-сургуулийн өөрийн удирдлагыг бэхжүүлж, эрх зүйн орчинг сайжруулах,

-боловсролын салбар дахь үйл ажиллагааг боловсронгуй болгох шинэчлэл, өөрчлөлтийн бүтээлч санаачилгыг бүхий л талаар дэмжих.

2. Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургуулийн хэмжээ, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой болгож, зураглалыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх:

-цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны байршил, хүчин чадлын судалгаа хийх,

-сургууль, цэцэрлэгийн бүтэц хэв шинжийн хөгжил, хэмжээ, байршлын хэрэгцээний чиг хандлагыг тодорхойлох,

-сургууль, цэцэрлэгийн бүтэц хэмжээ, хэв шинжийн зураглалыг шинэчлэхэд нийгэм, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлого, тусгаар тогтнол, аюулгүй байдал, боловсролын чанарын баталгааг хангах хэрэгцээ шаардлага, хүн амын нягтрал, иргэдийн санал хүсэлтийг тооцон боловсруулах.

### **Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

Хөтөлбөрийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхтэй уялдуулан 2021 он хүртэл хоёр үе шаттай хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат:	2010-2015 он
Хоёрдугаар үе шат:	2016-2021 он

### **Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

-улсын төсөв;

-хандивлагч орон, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлуулсан хөрөнгө, зээл, тусламж, хандив;

-бусад эх үүсвэр.

### **Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур**

Хөтөлбөрийн стратегийн зорилго, зорилтын биелэлтийг үнэлэхэд дараахь чиглэлийг үндэслэл болгон баримтална:

-хөтөлбөрийн хэрэгжилт нь Монгол Улсад бүх нийтийн насан туршийн боловсролын тогтолцоо төлөвшүүлэхэд чиглэсэн байна.

-хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын боловсролын тогтолцооны цвацдын хөгжлийг хангахад чиглэсэн байна.

### **Ес. Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, тайлагнах тогтолцоо**

-хөтөлбөрийн стратегийн зорилт, дэд зорилтуудыг Боловсролын мастер төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлнэ.

-Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, бодлого, төлөвлөгөөнд "Боловсрол" үндэсний хөтөлбөрийн зорилтуудыг тусгаж, холбогдох хуульд заасан журмын дагуу батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

-Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэлд "Боловсрол" үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааг тусган төлөвлөж хэрэгжүүлнэ.

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо болон бусад яам, агентлагтай хамтран ажиллах стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч хяналт тавих, тайлагнах, үнэлж дүгнэх чиг үүргээ хэрэгжүүлэх замаар үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.

-Засгийн газраас хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд явцын үнэлгээг жил бүр хийх бөгөөд нэгдсэн хяналт-шинжилгээг хоёр үе шаттай хийнэ.

Нэгдүгээр үе шат: 2015 оны 6 дугаар сар  
Хоёрдугаар үе шат: 2021 оны 6 дугаар сар

### Арав. Хүлээгдэж байгаа гол үр дүн

#### Стратегийн зорилт 1

-хүүхдийн хөгжих боломжийн тэгш бус байдлыг бууруулж, бага боловсролын хүртээмж, чанар, дотоод үр ашиг дээшилнэ;

-цэцэрлэгийн материаллаг бааз болон сургалтын үйл ажиллагааны орчин сайжирснаар хүүхдүүд аюулгүй, эрүүл, эсэн мэнд өсөж хөгжих, чанартай үйлчилгээг хүртэх боломж өргөжинө;

-6 настай хүүхдүүд сургуульд бүрэн хамрагдсан байна;

-суралцах боломж нь хязгаарлагдсан, эрх нь зөрчигдсөн хүүхдүүд боловсролын үйлчилгээнд бүрэн хамрагдах бололцоотой болно;

-боловсрол нөхөн олгох тогтолцоо бүрдэнэ;

-боловсролын хөгжилд оруулах нийгмийн хариуцлага, оролцооны үр өгөөж нэмэгдэж, суралцагчдын чанартай боловсрол эзэмшихэд шаардагдах орчин нөхцөл сайжирна;

-бага, суурь боловсрол эзэмшигчид нь дараагийн түвшний чанартай боловсрол эзэмших, бие даан ажиллаж, амьдрах тэгш боломж нэмэгдэнэ;

-боловсролын төсвийн санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэж, тэдгээрийн чанартай, үр ашигтай зарцуулах арга, механизм бүрэлдэнэ;

-боловсролын үйл ажиллагаа бүх нийтийн үйл хэрэг болно;

-2015 оноос ерөнхий боловсрол 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжинэ;

-насан туршийн сургалтын орчин бүрдэж, амьдралын чанар дээшилснээр ядуурал буурна.

#### Стратегийн зорилт 2

-ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх болон цогц чадамжид суурилсан сургуулийн



өмнөх, бага, дунд боловсролын стандарт, сургалтын хувилбарт төлөөлөгөө, хөтөлбөрүүд болсворч тогтвортой мөрдөгдөнө;

-ерөнхий боловсролд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна;

-олон улсын жишигт ойртсон болон IB (International Baccalaureate) хөтөлбөрт хамрагдах эрхтэй сургуулийн тоо нэмэгдэнэ;

-ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг XXI зууны шинэ хандлагад зохицон өөрчлөгдөнө;

-иргэдийн иргэний болон тогтвортой хөгжлийн боловсролын чанар дээшилнэ;

-ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хангамж сайжирна;

-англи хэл нь бүх нийтийн голлох гадаад хэл болно;

-боловсролын мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ боловсронгуй болно;

-боловсрол судлалын үндэсний чадавхи дээшилнэ.

### Стратегийн зорилт 3

-багш бүрийн мэргэжлийн болон арга зүйн хөгжилд бодит ахиц гарч, шинэ стандарт, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой болно;

-багш, удирдах ажилтан бэлтгэх тогтолцоо шинэчлэгдсэн байна;

-бүх сургууль мэргэжлийн багшаар бүрэн хангагдана;

-багш ашиглалтын хувийн жин оновчтой болно;

-багшийн хөгжлийн эрэлт хэрэгцээнд суурилсан сургууль төвтэй мэргэшил дээшлүүлэх тогтолцоо төлөвшсөн байна;

-ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэшлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо нэмэгдэнэ;

-багшийн нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоо төлөвшиж,



багшийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд нэмэгдэнэ.

#### Стратегийн зорилт 4

-далхийн нэр хүндтэй их, дээд сургуулиудын хөтөлбөрөөр хичээллэдэг салбар сургуулиуд бий болсон байна.

-магистр, докторын сургалт олон улсын стандартын түвшинд ойртоно.

-Монгол Улсын үндэсний эрх ашигт нийцсэн гадаадын хөрөнгө оруулалттай сургууль байгуулах боломж бүрдэж, хэрэгжинэ.

#### Стратегийн зорилт 5

-зайны сургалтын найдвартай ажиллагаа бүхий сүлжээ бий болсон байна.

-мэргэжлийн боловсрол, сургалтын үйлчилгээ сайжирснаар хүн амын хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, ядуурал, ажилгүйдэл буурна.

-үндэсний мэргэжилтэй ажилчдын чадавхи сайжирснаар үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, эдийн засгийн өсөлт бий болоход дэмжлэг үзүүлнэ.

-Монгол Улсын дээд боловсролын өрсөлдөх чадвар, үнэлэмж дээшилнэ.

-дээд боловсролын салбарын хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлж, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг хөгжүүлснээр иргэдийн чанартай дээд боловсрол эзэмших, тасралтгүй суралцах боломж нэмэгдэнэ.

-Монгол Улсын үндэсний мэргэжилтний чадавхи дээшилж, эдийн засгийн өсөлтөд үр нөлөөгөө үзүүлнэ.

-их, дээд сургуулиар бэлтгэж байгаа мэргэжлийн чиглэл, түүний төлөвлөлт нь үндэсний эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцдэг болно.

-их, дээд сургуульд элсэгчдийн мэргэжлийн төрөл оновчтой болж, оюутны нийгмийн хамгаалал, суралцах боломж өргөжсөн байна.

#### Стратегийн зорилт 6

-сургууль төвтэй менежментийн соёл төлөвшсөн байна.



-боловсролын салбарт шийдвэр гаргах эрх мэдлийн хуваарилалт оновчтой болсон байна;

-мэдээлэлд суурилсан менежментийн арга зүй, соёл төлөвшинө;

-үнэлгээ, оношилгооны оновчтой, бодитой байдал дээшилсэн байна;

-сургууль, цэцэрлэгийн хэмжээ, бүтэц, хэв шинж, байршил оновчтой тогтоогдоно;

-боловсролын хүртээмж, чанар, тэгш байдлыг цогцоор нь оновчтой шийдвэрлэх үндсэн нөхцөл хангагдана;

-багшийн ажлыг оновчтой төлөвлөх, үнэлэх дүгнэх, урамшуулан дэмжих тогтолцоо төлөвшинө;

-хүн амын шилжилт, хөдөлгөөнд эерэг өөрчлөлт гарна;

-боловсролын чанарын үнэлгээний шинэ тогтолцоо бий болно.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2010 оны 04 дүгээр  
сарын 02-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны  
дэгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн  
холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг  
хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан, П.Очирбат, Ж.Амарсанаа /илтгэгч/, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Г.Агар-Эрдэнийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.9, 32.2.1 дэх заалт,





мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч, иргэн Н.Ариунболд, Н.Хайдав, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд, Д.Балдан-Очир нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2010 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн "Шинжээч томилох тухай" 25 дугаар тогтоолоор томилогдсон шинжээч Л.Болд, Ш.Чоймаа, М.Мөнхбат нарын гаргасан "Шинжээчдийн нэгдсэн дүгнэлт"-ийг Цэцийн дунд суудлын хуралдаанд сонсгов.

**Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Ариунболд Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:**

"... Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар маргаантай асуудлаар Улсын Их Хуралд оруулсан дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний эзгүйд орлогч нь нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байх, түүнчлэн Цэцийн дүгнэлтийг танилцуулж буй этгээдээс асуулт асуух, хариулт өгөх хэм хэмжээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тогтжээ. Харин энэхүү хэм хэмжээ нь "шүүх" үндсэн чиг үүрэг бүхий Үндсэн хууль зөрчсөн маргааныг магадлан шийдвэрлэх эрх бүхий байгууллагаас Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэхэд нөлөөлөхүйц зохицуулалт болсон байна. Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн маргааныг Цэц эцэслэн шийдвэрлэх тул Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс өөрийн үзэл бодлоо Үндсэн хуулийн цэцэд тулгах, улмаар хэнээс ч үл хараат байх Цэцийн гишүүдийн итгэл үнэмшилд нөлөөлөхийг оролдож болзошгүй нь Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн хэнээс ч хараат бус байх зарчимтай нийцэхгүй байна.

Цэцийн дүгнэлттэй холбоотойгоор дүгнэлт танилцуулж буй этгээдээс гишүүд асуулт асуух нь нөгөө талд хариулах үүргийг бий болгож байгаа бөгөөд энэ нь Цэц шийдвэрээ төрийн эрх барих дээд байгууллагын өмнө хамгаалах агуулгатай болсон байх тул Үндсэн хуулийн хэрэгжилтийг чандлан сахиулах баталгаа болсон Үндсэн хуулийн цэцийн онцгой статусыг зөрчсөн гэж үзэж байна.

Үндсэн хуулийн цэц нь есөн гишүүнээс бүрдэж, хэн нэг гишүүн нь илүү эрх эдлэхгүйгээр шийдвэрээ олонхийн саналаар



гаргадаг хамтын удирдлагатай байгууллага тул үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй холбоотой асуудал буюу Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаантай асуудлаар уул байгууллагыг нэг гишүүн нь тэр дундаа дарга эсвэл орлогч нь төлөөлөхгүй. Тиймээс Цэцийн шийдвэрийг Цэцийн дарга эсвэл орлогч нь дангаар Цэцийг төлөөлөн тайлбарлах, хамгаалах боломжгүй юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтад "Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна", мөн зүйлийн 32.2.1 дэх заалтад "Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна" гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана", Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. ...", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино" гэж заасантай нийцсэн эсэхийг шалгаж өгнө үү" гэжээ.

**Хоёр. Иргэн Н.Ариунболд Үндсэн хуулийн цэцэд дахин нэмэгдүүлсэн шаардлага ирүүлжээ. Уг шаардлагадаа:**

"Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай Цэцэд гаргасан мэдээллийн шаардлагыг дараах байдлаар нэмэгдүүлж байна:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.9 дэх заалт мэдээлэлд дурьдсан Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэхийг тогтоолгох" гэжээ.



**Гурав. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Хайдав Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:**

"Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, шүүхийн тогтоолыг Улсын Их Хурлын Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхдээ Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга эсвэл орлогч дарга, шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч танилцуулж, Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж, тайлбар авч байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон Үндсэн хуулийн цэц түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ хэнээс ч хараат бус байж зөвхөн Үндсэн хуульд захирагдах, шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохгүй байх зэрэг зарчмыг гажуудуулж байна гэж үзэж байна.

...2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтад "...Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь...", 32.1.9 дэх заалтад "... Цэцийн дарга, түүний орлогчоос...", мөн зүйлийн 32.2.1 дэх заалтын "...Цэцийн дарга, түүний эзгүйд орлогч нь...", 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт "...Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч ... дарга нь ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна. Иймд дээрх асуудлыг хянан хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье" гэжээ.

**Дөрөв. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд, Д.Балдан-Очир нар Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:**

"...Мэдээлэл гаргагч нь мэдээллийн үндэслэлдээ Цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байх, Цэцийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн асуулт асууж, хариулт авах хэм хэмжээ нь Үндсэн хуулийн цэц түүний гишүүн хэнээс ч хараат бус байх зарчимтай нийцэхгүй, Цэцийн гишүүний итгэл үнэмшилд нөлөөлөхийг оролдож болзошгүй, маргааныг эцэслэн шийдвэрлэхэд нөлөөлөхүйц зохицуулалт болсон талаар бичсэн байна.

Түүнчлэн мэдээлэл гаргагч "дүгнэлт танилцуулж буй этгээдээс асуулт асууж байгаа нь Үндсэн хуулийн цэцийн онцгой статусыг зөрчсөн"



хэмээн үзжээ.

Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн хараат бус байна гэдэг нь дараах байдлаар нотлогдож байгаа билээ. Үүнд:

Нэгдүгээрт, Цэц есөн гишүүнтэй, тэдгээрт нэр дэвших хүнийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагаас тэнцүү тоогоор санал болгодог нь Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдлыг тэнцвэржүүлж, улмаар баталгаажуулж байна.

Хоёрдугаарт, Үндсэн хуулиар Цэцийн бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орохыг хориглосон нь Цэцийг төрийн эрх мэдэл, улс төрийн нөлөөллөөс ангид байлгах эрх зүйн үндсийг тогтоосон.

Гуравдугаарт, Цэцийн даргыг гишүүд дотроосоо дэвшүүлэн, нууц санал хураалт явуулж, олонхийн санал авсан хүнийг сонгодог. Улсын Их Хурлаас шууд томилдоггүй

Дөрөвдүгээрт, Цэцийн маргаан хянан шийдвэрлэсэн үйл ажиллагаатай нь холбоотойгоор хариуцлага ногдуулах, гаргасан шийдвэрийг нь хянах эрх бүхий байгууллага үгүй. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналтыг Цэц хэрэгжүүлнэ.

Тавдугаарт, Цэц үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх бие даасан төсөвтэй. Түүнийгээ өөрөө захиран зарцуулна.

Зургадугаарт, Цэцийн гишүүний халдашгүй байдлыг хуульчилан тогтоосон нь Цэцийн хараат бус байдлын баталгаа юм.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн өргөдөл, мэдээлэл хүлээн авах, Цэцийн хуралдаанд бэлтгэх, маргаан хянан хэлэлцэхэд нь хэн боловч дарамт шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох аливаа бусад хэлбэрээр нөлөөлөхийг хориглосон заалтыг Улсын Их Хурлаас хэлбэрэлтгүй мөрдөж ирсэн. Ийнхүү Цэцийн гишүүний хараат бус байдлын баталгааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар тус тус хуульчилан баталгаажуулсан болно.

Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болохын хувьд Улсын Их Хурал асуудлыг нь шийдвэрлэж байх тусгайлсан журам тогтоон мөрдөж байгаа билээ.



Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх, санал хураалт явуулах, дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах процедур журмыг хуульчилсан юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дээр дурдсан заалтууд Цэцээс маргааныг эцэслэн шийдвэрлэхэд нөлөөлж болохуйц Улсын Их Хурлын гишүүдээс үзэл бодлоо тулгасан, Цэцийн онцгой статусыг зөрчсөн гэж үзэхгүй байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулахаар заасан, улмаар Улсын Их Хурал нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталдаг төлөөллийн байгуулагын хувьд тодорхой асуудал хэлэлцэж цөөнхийн саналыг хүндэтгэн сонсож, олонхийн саналаар шийдвэр гаргадаг ерөнхий зарчимтай болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасанчлан Улсын Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж, хариулт авах, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах бүрэн эрхтэй билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан ерөнхий зохицуулалт ёсоор Улсын Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа асуудлаар үүний дотор Цэцийн дүгнэлтийн талаар асуулт асууж, хариулт авч байгаа явдлыг Үндсэн хууль зөрчсөн зохицуулалт гэж үзэхгүй бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хэлбэр юм.

Харин Цэцийн гишүүн маргааныг хянан шийдвэрлэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдан дотоод итгэлээрээ асуудлыг шийдвэрлэх билээ.

... Мэдээлэл гаргагч Цэц есөн гишүүнтэй шийдвэрээ олонхийн саналаар гаргадаг хамтын удирдлагатай байгууллага тул Цэцийн дарга, эсвэл орлогч нь дангаараа Цэцийн төлөөлөн тайлбарлах, хамгаалах боломжгүй хэмээн үзжээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн ийнхүү зохицуулалтыг боловсруулахдаа Цэцийн дүгнэлтийг



Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулж байх /Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон Улсын Их Хурлын 2001 оны 61 дүгээр тогтоолын 15.1.1, 15.3.2 дахь заалт/-аар заасныг Цэцийн дарга, түүний эзгүйд орлогч нь танилцуулахаар тогтоожээ. Үндэслэл нь: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Цэцийн дарга Цэцийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцана мөн зүйлийн 6 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэцийн орлогч даргаар Цэцийн бүрэлдэхүүнд хамгийн олон жил ажилласан гишүүн, хэрэв энэ шаардлагыг хэд хэдэн гишүүн нэгэн адил хангасан байвал тэдгээрийн хамгийн ахмадыг Цэцийн дарга томилж байхаар заасан зүйлтэй нийцүүлэх зорилгыг агуулсан юм.

Зөвлөлдөх тасалгаанд хамтын зарчмаар маргааныг хянан хэлэлцэж, олонхийн саналаар гаргасан шийдвэрийг Цэцийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцах эрх хэмжээ бүхий субъект Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь Улсын Их Хуралд танилцуулж байгаа явдал бусад хууль тогтоомжийн заалтад нийцэж, Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй зүйл юм.

Харин хуулийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл гарч байгаа бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтыг өөрчлөх боломжтой юм.

Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгналтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулж байдаг одоогийн зохицуулалт нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим болсон Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ...", Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчөөгүй болно" гэжээ.

**Тав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд, Д.Балдан-Очир нараас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хүсэлтийн тухай:**

Үндсэн хуулийн цэц дээрх хүсэлтийг хянан хэлэлцээд 2010 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 07 тоот магадлал гаргасан байна. Уг магадлалын тогтоох хэсэгт:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг



хойшлуулсугай.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэх Цэцийн дунд суудлын хуралдааныг 2010 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 9:30 цагаас Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийсүгэй” гэжээ.

#### **ҮНДЭСЛЭЛ:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд “оруулна” гэж тодорхой заасан байтал 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Цэцийн дүгнэлтийг “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд ... танилцуулна” болгон өөрчилж, утга санааг нь гажуудуулжээ.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулах журам тогтоосон нь шүүхийн бие даасан байдал, Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн хараат бус байдлын зөрчмэг алдагдуулсан байна.

3. Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцсон Цэцийн аль нэгэн гишүүн Цэцийн дүгнэлтийг зөвхөн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах нь Үндсэн хуульд харшлахгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

#### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай



хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтад "Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна.", 32.1.9 дэх заалтад "Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд Цэцийн дарга, түүний орлогчоос болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.", 32.2.1 дэх заалтад "Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна.", мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт "Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулна." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж гэгцхүү хуульд захирагдана.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.", Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Үндсэн хуулийн цэц түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гэгцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, 32.1.9 дэх заалт, 32.2.1 дэх заалт, мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.", Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. ..." гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтын "Цэцийн дүгнэлтийг





Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна.”; 32.1.9 дэх заалтын “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд Цэцийн дарга, түүний орлогчоос болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.”; 32.2.1 дэх заалтын “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна.”; мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулна.” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2010 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 2010 оны хаврын чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Ж.БЯМБАДОРЖ**

**ГИШҮҮД**

**Н.ЖАНЦАН**

**П.ОЧИРБАТ**

**Ж.АМАРСАНАА**

**Д.МӨНХГЭРЭЛ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” мөхтгэлийн редакция

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin\_medeelal@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэл хэсэгт хэвлэв.  
Утас 329487